

МУИС-ИЙН ЗАВХАН СУРГУУЛЬ

СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/2016-2024/

МУИС- ийн Завхан сургуулийн Эрдмийн зөвлөлийн
2016 оны 5-р сарын 23-ний өдрийн хурлаар хэлэлцэн батлав.

Улиастай

2016

ГАРЧИГ

МУИС-ИЙН ЗАВХАН СУРГУУЛИЙН 2016-2024 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

ӨМНӨХ ҮГ

- **БҮЛЭГ 1. СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- **БҮЛЭГ 2. 2009-2015 ОНЫ СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ**

2.1 МУИС-ийн Завхан сургуулийн 2009-2015 оны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тойм

2.2 МУИС-ийн Завхан сургуулийн орчин ба нөхцөл байдлын шинжилгээ

2.3. Стратегийн төлөвлөгөөг шинэчлэх шаардлага

- **БҮЛЭГ 3. 2024 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ, ЕРӨНХИЙ ЗОРИЛГО**
- **БҮЛЭГ 4. 2024 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР, ХҮРЭХ ҮР ДҮН**

4.1. Судалгааны хамрах хүрээ, түвшинг үндэсний хэмжээний тэргүүлэх жишигт нийцүүлэх.....

4.2. Сурах ба багшлах үйл явцыг үндэсний хэмжээний тэргүүлэх түвшинд хүргэх.....

4.3. Хүний хөгжлийг орчин үеийн шаардлагын түвшинд хүргэх.....

4.4. Нийгэмд мэдлэгээр манлайлж, нийгмийн тэргүүний үйлчлэгч нь байх.....

4.5. Байгууллагын бие даасан байдлыг хангаж, менежментийн олон улсын шилдэг арга барилыг нэвтрүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангах.....

4.6. Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийн тойм

4.7. Эрсдлийн удирдлага

4.8. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, хяналт-үнэлгээ.....

ӨМНӨХ ҮГ



МУИС-ийн Завхан сургууль нь үүсэн байгуулагдсан үеэсээ эхлэн Эх орондоо мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх хариуцлагатай үүргээ нэр төртэй биелүүлж, бүс нутгийн хэмжээнд Их сургуулийн сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж ирсэн төрийн өмчийн сургууль юм. Үүний нэг тод жишээ нь өнөөдөр манай баруун бүсийн аймгуудад эдийн засаг, банк, санхүү, нягтлан бодох бүртгэл, маркетингийн чиглэлээр ажиллаж буй нийт боловсон хүчний 60 гаруй хувийг тус сургуулийн төгсөгчид эзэлж байгаа явдал юм.

Сүүлийн жилүүдэд тус сургууль нь хөтөлбөрийн шинэчлэлийг эрчимтэй хийснээр сургалтынхаа агуулга, бүтцийг шинэчлэх, багш нарынхаа мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, сургалтын орчин, материаллаг баазаа сайжруулах талаар олон талт үйл ажиллагаа явуулж, тодорхой амжилтанд хүрч байна.

Тус сургуулийн дэргэд Баруун бүсийн судалгааны төв байгуулагдаж, үндэсний болон олон улсын байгууллагуудтай хамтран бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх судалгаануудыг амжилттай гүйцэтгэж, шат шатны байгууллагуудад тайлангаа хүлээлгэн өгч, бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшний байгууллага, хүмүүсийг бодит мэдээ, судалгаагаар ханган ажиллахын зэрэгцээ багш, судлаачдын судалгааны ажлуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахад ихээхэн анхаарч байна.

Тус сургуулийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа жилээс жилд өргөжиж, сургуулиуд хоорондын болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний ажлуудад оролцох, багш, оюутнуудад гадаадын их, дээд сургуулиудад суралцах, мэргэжил дээшлүүлэх өргөн боломж нээгдэж байна.

Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд мэргэшсэн, ур чадвартай, үнэ цэнэтэй ажилтнуудын хэрэгцээ өсч, гүйцэтгэх үүрэг нь улам бүр нэмэгдсээр байна. Үүнтэй уялдаж хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх шаардлага чухлаар тавигдах болов. Чухам ийм учраас тус сургуулийн өмнө

өнөөгийн бэлтгэж буй уламжлалт хөтөлбөрүүдээр үргэлжүүлэн бэлтгэхийн зэрэгцээ, инженер техник, технологи, гадаад хэлний хөтөлбөрүүдээр мэргэжилтэн бэлтгэх шинэ хэрэгцээ, шаардлага урган гарч байгааг онцгой анхааран ажиллаж байна. Ингэснээр манай сургуулийн бэлтгэн гаргаж байгаа мэргэжилтнүүд нь Монголын бүс нутгуудаас хөгжлөөрөө хамгийн их хоцрогдолтой байгаа баруун бүс нутгийн хөгжлийг урагшлуулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх хамгийн үнэт капитал болох юм.

Тус сургууль нь судалгаа - сургалтын байгууллага болохынхоо хувьд эрдэм шинжилгээ-судалгаа, сургалтыг хослуулан хөгжүүлж, МУИС-ийн судалгааны Их сургууль болох зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллаж байна.

Энэхүү стратеги төлөвлөгөө нь өмнөх жилүүдийн хөгжлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үргэлжлэл бөгөөд тус сургуулийн хөгжил дэвшлийн түүхэнд нэгэн томоохон алхам, бодитой шинэчлэл хийж буй баримт бичиг юм.

МУИС-ийн Завхан сургуулийн эрдмийн хамт олон энэхүү стратеги төлөвлөгөөнд дэвшүүлсэн хөгжлийн үндсэн чиглэлүүд, зорилго, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхийн төлөө итгэл төгс ажиллах болно.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!

МУИС-ийн Завхан сургуулийн захирал, дэд проф, доктор М.Эрдэнэчимэг

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Баримталсан зарчим

Чөлөөт нийгэмд зах зээлээ өргөтгөх, хэрэглэгчээ дээдлэх, чанарыг эрхэмлэх, хүнээ хөгжүүлэх зэрэг нь аль ч байгууллагын өмнө байнга тавигдаж байдаг нийтлэг хэрэгцээ шаардлага юм. Орчин үед энэхүү хэрэгцээ, шаардлагаа чухамхүү байгууллагын хөгжлийн стратеги төлөвлөлтөөр дамжуулан хэрэгжүүлдэг. Бид удирдахуйн шинжлэх ухаанд томъёолсон: “стратеги бол байр суурь”, “стратеги бол төлөвлөлт”, “стратеги бол зохион байгуулалт”, “стратеги бол арга ухаан”, “стратеги бол менежментийн иж бүрдэл мөн” гэсэн зарчмуудыг иш үндэс болгож, стратеги төлөвлөгөөний “чигийг заадаг”, “хүчийг нэгтгэдэг”, “байгууллагын дүр төрхийг тодорхойлдог” зэрэг онцлог, давуу талууд дээр суурьлан өөрийн байгууллагын хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулав.

Энэхүү стратегийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд дээд боловсролын дэлхийн чиг хандлагыг тооцох, үндэсний хэмжээний болон бүс орон нутгийн их, дээд сургуулиудын хүрсэн түвшин, мөн дотоод, гадаадын шилдэг сургуулиудын стратеги төлөвлөгөөгөө боловсруулсан арга, туршлага зэргийг судлаж, стратеги төлөвлөгөөндөө тусгахыг хичээлээ.

Мөн уг төлөвлөгөөг манай улсын төр, засгаас явуулж буй үндэсний хөгжлийн болон бүсчилсэн хөгжлийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд өөрийн сургуулийн гүйцэтгэх үүргийг өндөржүүлж, оруулах хувь нэмрийг арвижуулах замаар бүс нутгийн болон улс орны хэмжээнд сургуулийнхаа эзлэх байр суурийг улам бэхжүүлэх гэсэн үндсэн зорилго, мөн МУИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө /2016-2024/ ний үзэл баримтлал, зорилго, зорилтууд зэрэгт тулгуурлан сургуулийнхаа хөгжлийн өнөөгийн бодит байдал, хүчин чадалд тал бүрээс нь дүн шинжилгээ хийж, ирээдүйн чиг хандлага, хүрэх төвшингээ тодорхойлж, энэ талаар сургуулийн удирдлагын баримтлаж буй бодлого, бүх алба, нэгж,

багш, оюутан, ажилтан, ажилчид, нийт хамт олныхоо санал бодлыг авч тусгахыг хичээсэн болно.

Цогц баримт бичиг

Энэхүү стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд дараах гурван үндсэн баримт бичгийг хамтад нь боловсрууллаа. Үүнд:

- МУИС-ийн Завхан сургуулийн 2009-2015 оны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээний тайлан.
- МУИС-ийн Завхан сургуулийн 2016-2024 оны сургуулийн орчин болон нөхцөл байдлын шинжилгээний тайлан .
- МУИС-ийн Завхан сургуулийн 2016-2024 онд хөгжүүлэх стратегийн төлөвлөгөө зэрэг болно.

Үйл ажиллагааны зохион байгуулалт

Стратегийн төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааг дараах үе шаттайгаар хэрэгжүүллээ.

Үүнд:

- МУИС-ийн Завхан сургуулийн захирлын 2015 оны 02-р сарын 17-ний өдрийн А/15 тоот тушаалаар уг стратеги төлөвлөгөөг боловсруулах 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдав.
- Ажлын хэсэг МУИС-ийн Завхан сургуулийн 2009-2015 оны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд үнэлгээ хийж, сургуулийн 2016-2024 оны орчин, нөхцөл байдалд шинжилгээ хийж, тэдгээрт үндэслэн сургуулийг 2016-2024 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулав.
- Ажлын хэсэг стратеги төлөвлөгөөний төслийн анхны хувилбарыг сургуулийн Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж зөвлөмж авсны үндсэн дээр сургуулийн Хамт олны зөвлөл, Үйлдвэрчний зөвлөл, Оюутны зөвлөл, Төгсөгч, дэмжигчдийн холбоо, алба, нэгж, тэнхмүүд болон нийт багш, ажилтан, ажилчид, оюутнуудын дунд өргөн хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдгээрийн санал бодлыг тусгав.
- Стратеги төлөвлөгөөний шинэчлэсэн хувилбаруудыг сургуулийн Захиргааны зөвлөлийн хуралдаанаар 4 удаа хэлэлцүүлж, 5 дахь хэлэлцүүлгээр баталгаажуулж, улмаар сургуулийн Эрдмийн зөвлөлд танилцуулан хэлэлцүүлж батлуулав.

Ийнхүү сургуулийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг аль болох сургуулийн удирдах бүрэлдэхүүн, алба, нэгжүүд, нийт хамт олны өргөн оролцоог хангах зорилгоор олон үе шаттайгаар хэлэлцүүлэн боловсруулсан болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

2009-2015 ОНЫ СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

2.1. 2009-2015 оны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тойм

Манай сургууль 2009-2015 оны стратеги төлөвлөгөөгөө “Сургуулийн статус, эрх зүйн орчин”, “Сургуулийн бүтэц, зохион байгуулалт”, “Сургалтын бодлого, зохицуулалт”, “Эрдэм шинжилгээ, судалгааны ажил”, “Хүний нөөцийн чадавхи”, “Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж”, “Материаллаг бааз, тохижилт, соёлжилт”, “Санхүү, эдийн засгийн хүчин чадал”, “Гадаад харилцаа, хамтын ажиллагаа” гэсэн хөгжлийн 9 үндсэн чиглэлийн хүрээнд боловсруулан ажилласан юм. Эдгээрийн биелэлтийг тоймлон авч үзвэл.

- Сургуулийн статус, эрх зүйн орчин, Сургуулийн бүтэц, зохион байгуулалт”-ын хүрээнд дэвшүүлсэн зорилтууд бүрэн биелэгдсэн.

- Сургалтын бодлого, зохицуулалтын хүрээнд нийт 13 зорилт дэвшүүлснээс бүрэн биелэгдсэн- 4, хагас биелэгдсэн-5, биелэгдээгүй- 4. Ерөнхий дүн 69.2 %,

-Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд нийт 7 багц зорилт дэвшүүлснээс бүрэн биелэгдсэн - 6, биелэгдээгүй - 1. Ерөнхий дүн – 85.7%,

-Хүний нөөцийн чадавхийн хүрээнд нийт 7 багц зорилт дэвшүүлснээс бүрэн биелэгдсэн – 3, хагас биелэгдсэн – 3, биелэгдээгүй – 1. Ерөнхий дүн 85.7%

- Нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарын хүрээнд 4 багц зорилт дэвшүүлснээс бүгд биелэж Биелэлт 100%

- Материаллаг бааз, тохижилт, соёлжилтын хүрээнд 9 багц зорилт дэвшүүлснээс бүрэн биелэгдсэн -3, хагас биелэгдсэн - 4, биелэгдээгүй – 2. Ерөнхий дүн 77.7%.

- Гадаад харилцааны хүрээнд нийт 3 багц зорилт дэвшүүлснээс биелэгдсэн - 3, Ерөнхий дүн 100%

- Санхүү, эдийн засгийн хүчин чадал” –ын хүрээнд биелэгдсэн – 5, биелэгдээгүй -1, Ерөнхий дүн 80%.

Ерөнхий дүгнэлт

Сургуулийг 2009-2015 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний хүрээнд 9 үндсэн чиглэлээр нийт 50 зорилт дэвшүүлсэн. Эдгээрээс бүрэн биелэгдсэн 29, хагас биелэгдсэн 12, биелэгдээгүй 9. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт нийт дүнгээрээ 82.0 % - ийн биелэлттэй байна.

2.2. МУИС-ийн Завхан сургуулийн орчин ба нөхцөл байдлын шинжилгээ

МУИС-ийн Завхан Сургуулийн өнөөгийн нөхцөл байдлыг тус байгууллагын онцлогт тохируулан гадаад орчны макро шинжилгээ болон SWOT шинжилгээний аргачлалаар шаардлагатай үзүүлэлтүүдийг авч хийв.

Боломж:

Төр засгаас боловсрол, шинжлэх ухааны салбарт хэргэжүүлж буй гадаад харилцааны бодлого, чиглэл улам бүр өргөжиж хөрш зэргэлдээ болон хөгжингүй орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх гэрээ хэлэлцээр хийх, оюутан сургах, оюутан солилцоо хийх асуудлуудбагш, оюутны гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжлэгзүүлэх хөтөлбөрт ажлууд нэмэгдэж байгаа нь сургуулиудын хувьд гадаад харилцаагаа хөгжүүлэх, дэлхийн хэмжээний боловсролын үйл ажиллагаанаас суралцах, энэ чиглэлээр хөгжих боломжийг бүрдүүлж байна.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он)-ын бичиг баримтанд Монгол улсын төрөөс боловсролыг нийгмийн тэргүүлэх салбарболгон хөгжүүлж,дөрвөөс доошгүй их сургуулийг Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд хүргэнэ гэжээ. Тус зорилт нь гарцаагүй Монгол улсын ууганих сургуульд хамааралтай. Энэ бичиг баримтын хүрээнд Засгийн газар олон ажил,хөтөлбөр төлөвлөж хэрэгжүүлээд байгаагаас Японы Засгийн газрынзээлээр мянган инженерийг Японулсад бэлтгэх “Коосэн” хөтөлбөр, Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл” зэрэг нь МУИС-д олон боломжийг бүрдүүлээд байна.

БСШУЯ-аас Монгол улсын Их хуралд 2015 онд өргөн барьсан боловсролын тухай зарим хуулиудад өөрчлөлт оруулах төсөл нь их, дээд сургуулиудын бие даасан байдлыг хангаж, эрдэм шинжилгээ, инноваци бүрдүүлэх орчныг дэмжихэдчиглэж,өнгөрсөн 2 жилийн

хугацаанд МУИС дээр хийгдсэн бүтцийн болон хөтөлбөрийн шинэчлэл нь эрдэм шинжилгээ, инновацийг дэмжих бодлоготой уялдаа холбоотой байгаа нь сайшаалтай.

Сүүлийн жилүүдэд Монгол улсад шинжлэх ухаан, инновацийг улс эх орны бүхий л түвшинд анхаарч, төр засгаас бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө, хууль баталсан нь эрдэм шинжилгээ, инновацийг цаашид улам хөгжүүлж сургуулиас гарааны компани байгуулан ашигтай ажиллуулахын тулд шинжлэх ухаан, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг бэхжүүлж инновацийн тогтолцоо(экосистем)-г бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлээд байна.

Хүн амын 50 гаруй хувь нь боловсролын насны хүн байгаа тул урт хугацаанд дээд боловсролын эрэлт өсөх хандлагатай байна. Мөн НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-аас “Мэдлэгийн эдийн засаг”-т шилжиж буйг анхааруулаад нэлээд хэдэн жил болж байна. Монгол улсын төр, засаг мэдлэгт суурилсан эдийн засаг чухал гэдгийг ойлгож, боловсролын хөрөнгө оруулалтад нийгмийн бүхий л шатанд анхаарах болжээ. Хувийн хэвшлийн байгууллагууд ч инновацид суурилсан бизнес хийх ач холбогдлыг ойлгож энэ талын хамтын ажиллагааг эхлүүлэх оролдлогууд хийх нь нэмэгдсээр байна.

Мэдлэгийн эдийн засгийн гол хөдөлгүүр бол мэдээлэл харилцаа холбооны технологи, и-бизнес, компьютерчлагдсан загвар бөгөөд дээд боловсролын байгууллагын хувьд цахим номын сан, цахим болон зайны сургалт, судалгааны компьютерчлагдсан лабораториуд улам хөгжиж, түүнийг шинээр зохион бүтээх, нэвтрүүлэх, хөгжүүлэх, сургалт, судалгаандаа ашиглах хүний нөөцийн асуудлууд чухал болж байна. Манай сургуулийн зайн сургалтыг хөгжүүлэн ашиглаж МУИС-ийн бүрэлдэхүүний бусад сургуулиудтай холбогдон зарим хөтөлбөр, хичээлүүд дээр ялангуяа магистрын түвшний хичээлд технологийн дэвшлийг түлхүү ашиглах нь зардал хэмнэх, сургалт, судалгааны чанарыг дээшлүүлэх боломж бүрдэж байна. Нөгөө талаас технологийн дэвшил нь боломжийг авчрах боловч түүнтэй хөл нийлүүлэн алхахад гарах эрсдлүүдийг бас дагуулдаг.

Баруун бүс болоод аймаг орон нутгийн удирдлага, төр захиргааны байгууллагуудаас Хөгжлийн цогц бодлого, мөрийн хөтөлбөртөө бүс, орон нутгийн их дээд сургуулиудад түшиглэсэн ажлуудыг тусган хэрэгжүүлэхийн зэрэгцээ орон нутгийн бодлого, төлөвлөлтийг их сургуультай хамтарсан шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа

шинжилгээнд тулгуурлан боловсруулах талаар хамтран ажиллаж байгаа нь таатай боломжуудын нэг юм.

Эрсдэл:

Их, дээд сургуулиудын чансааг тодорхойлох үзүүлэлтүүдийн нэг чухал үзүүлэлт ньгадаад судлаач, оюутны тоо юм. Орон нутгийн сургуулийн хувьд гадаад оюутан элсүүлэх, гадаадын сургуулиудтай багш оюутан солилцоог хэрэгжүүлэх боломж төвийн их дээд сургуулиудаас хязгаарлагдмал байна.

Техник технологийн дэвшлээс үүдэн боловсролын салбарт онлайн болон зайны сургалтаар тодорхой сэдвийн хүрээнд заах нэг хичээлээс авахуулаад дээд боловсролын зэрэг олгох хөтөлбөрүүдийг гадаад, дотоодын их, дээд сургуулиуд,судалгааны институт, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд дэлхийн аль ч өнцөгөөс санал болгох болжээ.Зарим сургуулиуд тодорхой хичээлээ үнэтөлбөргүй, нээлттэйгээр цахим хуудсанд байршуулж байна. Дээд боловсролын салбарын өрсөлдөөн өдөр ирэх тусам ширүүсч, хэрэглэгчдийн сурах төлөв мөн өөрчлөгдөж байгаа.

Инновацийг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн боловч инновацийн соёл,экоосистемийн хөгжил сул байсаар байна. Инновацийн экосистемд элемент талаасаа боловсон хүчин, аж ахуйн нэгжүүд, институциуд, хөрөнгө гэх мэт хүчинзүйлс нөлөөтэй ч, тэдгээрийн мөн чанар, зорилго, сүлжээнд нэгдэх чадвар, соёл, прагматик хамтын ажиллагаа зэрэг нь илүү чухал байдаг.

Улс төрийн тогтворгүй байдал, зарим популист улс төрчдийн хандлага ньодоогоортөрөөс хараат байдалд үйл ажиллагаагаа явуулж байгаа төрийн өмчит их, дээд сургуулиудад сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт буурч эдийн засгийн таагүй нөхцөл бүрдэж ажилгүйдэл, хүн амын амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж буй байдал нь төвөөс алслагдсан, үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжлөөр сул баруун бүсийн хувьд хамгийн их байна.Энэхүү эдийн засгийн сөрөг нөлөө нь төгсөгчдийн ажлын байрыг хорогдуулж төр, хувийн хэвшлээс өгөх судалгааны тэтгэлгийн хэмжээг багасгах хандлагатай.

Техник технологи хөгжихийн хэрээр зарим ажлын байрууд шинээр бий болж, зарим нь үгүй болж байна. Энэ нь зарим талаараа бид ирээдүйд огт байхгүй ажлын байранд зориулж глобал зах зээл дээр өрсөлдөх чадвартай боловсон хүчин бэлтгэх шаардлагатай ч тулгарч байна. Мөн техник, технологийн хөгжилтэй зэрэгцэн хөгжих боломжийг багш, ажиллагсаддаа олгох шаардлагатай байна

Давуу тал:

- Сургуулийн статусын хувьд МУИС-ийн салбар сургуулиас, бүрэлдэхүүний сургуульд шилжсэн
- Хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжлийн эрэлт хэрэгцээг судласны үндсэн дээр шинэ мэргэжлийн анги нээх ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.
- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн бүтэц, агуулгыг бакалавр, магистрын түвшинд шинэчлэн баталж, оюутан элсүүлэн ерөнхий суурь хичээлүүдийг судалсны үндсэндээр мэргэжлийн хөтөлбөр сонгуулах зэрэг олон зарчмын томоохон өөрчлөлтүүдийг хийсэн
- Хөтөлбөрийн үндэсний магадлан итгэмжлэлийг амжилттай эхлүүлсэн. /Нягтлан бодох бүртгэл/
- Магистрын хөтөлбөрийг эхлүүлсэн төдийгүй эчнээ магистрын хөтөлбөрөөр суралцагчдын тоо 2009-2013 онуудад жил дараалан өссөн дүнтэй байна
- Кредит системийн тогтолцоо, SISI программын нэвтрэлтийг үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлж байна
- Санхүүгийн орчны хувьд төлбөрийн чадвар, санхүүгийн тогтвортой байдлын хүрээнд бүрэн биеэ даасан үйлжиллагаа явуулдаг
- Сургуулийн гадаад дотоод тохижилт, сургалтын орчин нөхцөл жилээс жилд сайжирч байна
- Сургалт эрдэм шинжилгээний ажилд шаардлагатай компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамж хүрэлцээ, интернет сүлжээний хангамж, хурд жилээс жилд сайжирч байна
- Тэнхмүүдийн дэргэдэх лабораториудыг байгуулж компьютер техник хэрэгсэл, программ хангамжийн асуудлыг улам бүр сайжруулж байна

- Судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд бүх шатанд ялангуяа ОУ-ын чанартай ажлуудын тоо нэмэгдэж багш нарын 90 гаруй хувь нь судлагааны ажил хийж, 40 гаруй хувь нь дотоод гадаадын төсөл, захиалгат ажилд оролцоод байна
- Гадаад дотоод харилцаа хамтын ажиллагаа улам бүр өргөжиж, хамтын ажиллагааны гэрээ байгуулсан гадаадын сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын тоо, гадаадад суралцагч багшийн тоо нэмэгдэж байна
- Аймгуудад төгсөгчдийн холбоотой түүнд түшиглэсэн төгсөгчдийн өргөн сүлжээтэй зэрэг давуу талуудтай

Сул тал:

- Инноваци бүтээх орчны хувьд судлаач багш нарын хичээл заах ачаалал өндөр, салбар дундын судалгаа бага хөгжсөн, бизнесийн байгууллагуудтай хамтынажиллагаа тааруу
- Сургалтыг тасралтгүй, чанартай явуулах чанарын удирдлагын систем бүрэлдээгүй.
- Нийт оюутны тоо жил бүр буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд элсэлтийн бодлогод онцгой анхаарах шаардлагатай
- Эрдмийн зэрэг цолтой багш нарын тоо цөөн
- Нийт орлогын дийлэнх хувийг сургалтын төлбөр бүрдүүлж байна. Нийт зардлын дийлэнх хувь нь цалин хөлсний зардал байгаа ба эрдэм шинжилгээ, инновацийн зардал нийт зардал бага хувийг эзэлж байна

2.3. Стратегийн төлөвлөгөөг шинэчлэх шаардлага

21-р зууны гараан дээр аливаа хөгжил дэвшил, сайн сайхан бүхний эх сурвалж болсон хүний оюун ухаан, гэгээрэл боловсролын асуудал, тэр тусмаа нийгмийн хөгжлийн хөдөлгөгч хүч болсон дээд боловсрол, түүний шинэчлэл нь шинэ эриний хөгжлийг тодорхойлогч талбар болон хувирч, энэ зүг рүү дэлхийн том, жижиг бүх л улс орнууд анхаарлаа төвлөрүүлэн, дор бүрнээ хүчин чармайлт гарган хөдөлмөрлөж байна.

Манай улсын хувьд дээд боловсрол, шинжлэх ухааны хүрээнд төрөөс баримталж буй бодлого өөрчлөгдөн шинэчлэгдэж, 2024 он гэхэд Монгол Улсын 4 их сургуулийг Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтаах зорилтыг дэвшүүлэв. Манай МУИС чөлөөт мэдлэг буюу “либерал арт” уламжлалд суурилсан, шинжлэх ухааны бүх чиглэлийг

хөгжүүлдэг Монгол Улс дахь цорын ганц сонгодог их сургууль болох зорилго дэвшүүлэн хөгжлийнхөө шинэ стратеги төлөвлөгөөг боловсруулав.

Иймд бид сургуулийнхаа хөгжлийн өнөөгийн хүрсэн төвшинг хадгалж, шинэ зууны чиг хандлагатай нийцүүлэх замаар цаашдын хөгжлийн үндсэн чиглэл, шийдвэрлэх асуудлууд, хүрэх үр дүнг онол-практикийн өндөр төвшинд тодорхойлж, Сургуулийнхаа эрхэм зорилгыг шинэчлэж, сургуулийн хөгжлийг шинэ шатанд гаргаж, Эх орныхоо үндэсний болон баруун бүсийн эдийн засгийн бүтцийг тэнцвэржүүлэх, улмаар хөгжлийг хурдасгахад чухал үүрэг, нөлөө бүхий үндэсний хэмжэний тэргүүлэх сургууль болгон хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МУИС-ИЙН ЗАВХАН СУРГУУЛИЙН 2020 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ, ЕРӨНХИЙ ЗОРИЛГО

3.1. Алсын хараа, эрхэм зорилго, уриа, үнэт зүйлс

АЛСЫН ХАРАА

Олон улсын стандартад нийцсэн, улс, бүс нутгийн хөгжил дэвшлийн тулгуур болсон загвар судалгааны их сургууль болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхий нийтийн хөгжлийн нийтлэг чиг хандлагад нийцсэн эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг явуулж, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай боловсон хүчин бэлтгэдэг үндэсний хэмжээний тэргүүлэх сургууль байхад оршино.

УРИА

Хүнлэг ёс, шинэ мэдлэг, бодит чадвар

ҮНЭТ ЗҮЙЛС

Академик эрх чөлөө

Сайн засаглал


Ниймийн ёс зүй

Уламжлал ба шинэчлэл

3.2. 2024 он хүртэлх хөгжлийн стратегийн тэргүүлэх чиглэлүүд

1. Судалгааны хамрах хүрээ, чанарыг үндэсний тэргүүлэх түвшинд нийцүүлэх
2. Сурах ба багшлах үйл явцыг үндэсний тэргүүлэх түвшинд хүргэх
3. Хүний хөгжлийг орчин үеийн шаардлагын түвшинд хүргэх
4. Нийгэмд мэдлэгээр манлайлж, нийгмийн тэргүүний үйлчлэгч нь байх
5. Байгууллагын бие даасан байдлыг хангаж, менежментийн олон улсын шилдэг арга барилыг нэвтрүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангах

3.3. Тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлэх схем



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

2026 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР, ХҮРЭХ ҮР ДҮН

Стратегийн зорилго 1. Судалгааны хамрах хүрээ, түвшнийг үндэсний хэмжээний тэргүүлэх жишигт нийцүүлнэ.

<p><u>Стратеги зорилт 1.1.</u> Судалгааны чиглэлийг өргөжүүлж, чанар, үр дүнг дээшлүүлнэ.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none">• Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан судалгааны чиглэлүүдийг өргөжүүлэх.• Тодорхой сэдвийн дор бүс, улс, олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлыг өөрийн сургууль дээр тогтмол зохион байгуулдаг болох• Эрдэм шинжилгээний бүтээлүүдээ олон улсын нэр хүндтэй сэтгүүлд нийтлүүлдэг болох• Сургуулийн бие даасан эрдэм шинжилгээний сэтгүүл гаргах
<p><u>Стратеги зорилт 1.2</u> Сургалт, судалгаа, антрепренёршипийн нэгдмэл тогтолцоог бий болгоно.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none">• Сургуулийн дэргэд гарааны шинэ компанууд төрүүлж, орон нутгийн аж ахуйн байгууллагуудтай хамтран ажиллах.• Тэдгээрийн үйл ажиллагаанаас эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтийн тодорхой хувийг бүрдүүлдэг болох.• Дотоод, гадаадын бизнес, үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох.
<p><u>Стратеги зорилт 1.3.</u> Инноваци бүтээх, дамжуулах тогтолцоог бүрдүүлнэ.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none">• Цахим сургалтаар дамжуулан инновацийг нэвтрүүлэх• Сургуулийн дэргэд “Бизнес-Инноваци” төв байгуулах• Судалгааны бүтээлийн цахим сантай болох.• Багш нар оюуны өмчийн хамгаалалт хийдэг болох.

<p><u>Стратеги зорилт 1.4.</u> Судалгааны нэгжүүдийн үйл ажиллагааг сайжруулах</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Судалгааны нэгж, багуудын тоог нэмэгдүүлж, ажлын чиглэлийг өргөжүүлж, түвшинг дээшлүүлэх • Судалгааны багийн гишүүдийн сургалт, судалгааны ажлын ачааллын зохистой харьцааг бий болгох • Судалгааны ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэнд оруулдаг болох. • Оюутнуудын эрдэм судлалын ажлын ур чадварыг нэмэгдүүлж, амжилтын түвшинг дээшлүүлэх.
<p><u>Стратеги зорилт 1.5.</u> Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүртээмж, хамрах хүрээг дээшлүүлнэ.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Шинжлэх ухааны салбар хоорондын судалгааны ажлыг өргөжүүлэх • МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудтай эрдэм шинжилгээ, судалгааны хамтын ажиллагааны хөтөлбөр боловсруулж ажиллах. • Дотоодын эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, төрийн бус байгууллагуудтай хамтарсан захиалгат, төсөлт судалгааны ажил хийж гүйцэтгэх. • Гадаадын их, дээд сургууль, төрийн бус байгууллагуудтай хамтран олон улсын хэмжээний судалгааны төсөл хэрэгжүүлэх. • Судалгааны ажлын урамшууллын тогтолцоог бий болгох.

Гүйцэтгэлийн шалгуур :

- Сургалтын шинэ хөтөлбөрүүдтэй уялдан судалгааны тэргүүлэх чиглэлийн тоо нэмэгдэж, салбар хоорондын судалгаа өргөжсөн байна.
- Бүс, орон нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн судалгааны үр дүнг нийтлэдэг бие даасан эрдэм шинжилгээний сэтгүүлтэй болсон байна.
- Өөрийн сургууль дээр 2 жил тутамд бүс, олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлыг тотмол зохион байгуулдаг болсон байна.

- Бүс, улс, олон улсын хэмжээнд 5-аас доошгүй судалгааны төсөл хэрэгжүүлсэн байна.
- Дотоод, гадаадын их, дээд сургуулиудын эрдэмтэдтэй хамтран эрдэм шинжилгээ, судалгааны 10-аас доошгүй хамтын бүтээл нийтлүүлсэн байна.
- Эрдэм шинжилгээ, судалгааны 3-аас доошгүй бүтээлийг олон улсын Томсон-Ройтерсийн индекстэй сэтгүүлд нийтлүүлсэн байна.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих чиглэлээр Бизнес, үйлдвэр, үйлчилгээний 3-аас доошгүй байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоож, үр дүн гаргасан байна.
- “Бизнес-Инноваци” төв, гарааны компани байгуулж, тэдгээрийн үйл ажиллагаанаас эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтийн 50 хүртэлх хувийг бүрдүүлдэг болсон байна.

Хүрэх үр дүн:

- Судалгаа, инноваци, антрепренёршип тогтолцооны эх суурь бүрэлдэнэ.
- Сургуулийн эрдэм судлалын сан хөмрөг арвижиж, судалгааны ажлын цар хүрээ өргөжиж, чанар чансаа дэшилж, үнэ цэнэ өснө.
- Бүс, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд сургуулийн оруулах хувь нэмэр сайжирна.
- Бүс нутгийг мэдлэгийн эдийн засагт шилжүүлэхэд бодит хувь нэмрээ оруулна.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд сургуулийн дотоод, гадаад нэр хүнд дээшилнэ.

Стратегийн зорилго – 2. Сурах ба багшлах үйл явцыг үндэсний тэргүүлэх түвшинд хүргэнэ.

<p><u>Стратеги зорилт 2.1.</u> Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг оновчтой болгож, судалгаанд суурилсан сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Дэлхийн шилдэг их, дээд сургуулиудын жишигт нийцсэн МУИС-ийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх. • Кредит системд бүрэн шилжиж, сургалтын “SISI” программыг бүрэн ашигладаг болох • Монгол улсын болон олон улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд
--	---

	нийцсэн бакалаврын хөтөлбөрүүдийг шинээр нээх.
<p><u>Стратеги зорилт 2.2.</u></p> <p>Сургалтын үйл ажиллагаанд антрепренёршип үзэл баримтлалыг нэвтрүүлнэ.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Сургалтанд антерпренёршип үзэл баримтлал зонхилсон хөтөлбөрүүдийг шинээр хэрэгжүүлэх. • Сургалтанд салбар дундын үйл ажиллагааг нэвтрүүлэх.
<p><u>Стратеги зорилт 2.3.</u></p> <p>Сургалтын чанар, үр дүнг сайжруулна.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа</u></p> <ul style="list-style-type: none"> • Үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн бакалаврын хөтөлбөрүүдийн тоог нэмэгдүүлэх. • Магистрын хөтөлбөрийн тоог нэмэгдүүлж, бие даасан “Хамгаалах зөвлөл”-тэй болно. • МУИС-тай “Багш солилцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлэх. • МУИС-тай “Оюутан солилцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
<p><u>Стратеги зорилт 2.4.</u></p> <p>“Зайн сургалтын төв”-ийг байгуулна.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Цахим сургалтын тоног, төхөөрөмж бүхий зайн сургалтын өрөө тасалгааг стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулах • Багш, оюутнуудын мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх ажлыг цахим сургалтын хэлбэрээр зохион байгуулдаг болох • Зарим ерөнхий суурийн хичээлүүд болон магистрын түвшний хичээлүүдийг зайн сургалтаар явуулдаг болох

Гүйцэтгэлийн шалгуур:

- Сургалтын “SISI” программын ашиглалт 100%-д хүрсэн байна.
- Зах зээлийн эрэлтэд нийцсэн бакалаврын 3-аас доошгүй шинэ хөтөлбөрийг нэмж хэрэгжүүлсэн байна.

- Бакалаврын 3-аас доошгүй хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлсэн байна.
- Магистрын 5 –аас доошгүй хөтөлбөр хэрэгжүүлж, бие даасан “Хамгаалах зөвлөл”-тэй болсон байна.
- Орчин үеийн сургалтын технологийг нэвтрүүлж, цахим сургалтыг бүх түвшинд хэрэгжүүлдэг болсон байна.

Хүрэх үр дүн:

- Сургалтын тогтолцоо нь олон улсын хөгжил, мэдлэг бүтээх зарчимд нийцсэн уян хатан, оновчтой болно.
- Сургалтын агуулга, стандарт, технологи нь дэлхийн жишигт ойртоно.
- Суралцагчид болон төгсөгчдийн мэдлэг, бодит чадвар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг бүрэн хангадаг болно.

Стратегийн зорилго-3. Хүний хөгжлийг орчин үеийн шаардлагын түвшинд хүргэх

<p><u>Стратеги зорилт 3.1.</u> Сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа</u></p> <ul style="list-style-type: none"> • МУИС-ийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлага, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд нийцүүлэн бүтцийн оновчтой, үр ашигтай тогтолцоонд шилжих • Бие даасан “Эрдмийн зөвлөл”-тэй болох
<p><u>Стратеги зорилт 3.2.</u> Багш нарыг сонгон шалгаруулах, мэргэжлийг дээшлүүлдэг шинэ тогтолцоонд шилжинэ.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Багш, ажилтнуудын мэдлэг, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх богино, дунд хугацааны тогтвортой хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх. • Багш, ажилтнууд ажлын байрандаа мэдлэг, мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх бүх талын нөхцөлийг бүрдүүлэх. • Гадаадын нэр хүндтэй их, дээд сургуулидын зочин профессорууд урилгаар ажиллаж, багш нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлдэг тогтолцоотой болох.

<p><u>Стратеги зорилт 3.3.</u> Багш нарыг эрдэмжүүлэх ажлыг шинэ түвшинд гаргана.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Эрдмийн зэрэг, цолтой багш нарын тоог нэмэгдүүлэх. • Дотоод, гадаадын магистрантур, докторантурт суралцагсдын тоог нэмэгдүүлэх. • Улс, олон улсын түвшинд бие даан судалгааны төсөл хэрэгжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх.
<p><u>Стратеги зорилт 3.4.</u> Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангана.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжиж, тогтвортой ажиллаж хөдөлмөрлөх ахуйн болон албаны тав тухтай орчинг бүрдүүлэх. • Цалин хөлсийг сургуулийн төсөв, улс орны инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлдэг болох. • Залуу багш нарт орон сууцны зээл авахад холбогдох дэмжлэгийг үзүүлэх.
<p><u>Стратеги зорилт 3.5.</u> Багш нарын гадаад улс орнуудад мэргэжил, дээшлүүлэх эрдмийн зэрэг хамгаалах тогтолцоог бий болгоно.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Багш нарын гадаад улс орнуудад мэргэжил дээшлүүлэх, магистрант, докторантурт суралцах, сонгон шалгаруулах бодлогын дүрэм, журам боловсруулж, хэрэгжүүлэх. • Гадаад улс орнуудад мэргэжил дээшлүүлэх, эрдмийн зэрэг хамгаалах багш нарын тоог нэмэгдүүлэх. • Магистрант, докторантуудыг дотоод, гадаадын болон олон улсын төрөл бүрийн тэтгэлэгт хөтөлбөрт өргөн хамруулах. • “Азийн их сургуулиудын холбоо” - ны гишүүн орнуудтай хамтын ажиллагаа өргөжүүлэх • Хамтын ажиллагаатай гадаадын их, дээд сургуулиудын тоог нэмэгдүүлэх

Гүйцэтгэлийн шалгуур:

- Сургуулийн үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт боловсронгуй болж, ажилтан албан хаагчдын орон тоо оновчтой, өрөө тасалгааны талбайн ашиглалт, санхүүгийн хэмнэлт, үр ашиг дээшилсэн байна.

- Нийт багш нарын 30 - аас дээш хувь нь эрдмийн зэрэг хамгаалсан байна.
- Гадаадын их, дээд сургуулиудын магистрантур, докторантурт суралцагсад 2-оос доошгүй тоогоор нэмэгдсэн байна.
- Нийт багш нарын 20-оос доошгүй хувь нь гадаадын их, дээд сургуульд мэргэжил дээшлүүлж, 10-аас доошгүй хувь нь магистр, докторын зэрэг хамгаалсан байна.
- Гадаад орнуудын 5-аас доошгүй их, дээд сургуулиудтай шинээр хамтын ажиллагаа тогтоосон байна.

Хүрэх үр дүн:

- МУИС- ийн шинэчлэлийн бодлого, үйл ажиллагаанд нийцсэн оновчтой, үр ашигтай бүтцэд шилжсэн байна.
- МУИС-ийн шаардлагад нийцсэн шилдэг тэргүүний багш, судлаачид багшлах боловсон хүчнээр хангагдсан байна.
- Хүний тал бүрийн хөгжлийг хангах нөхцөл бүрдсэн байна.
- Хүний нөөц, боловсон хүчний хөдөлмөрийн үр дүнг шинжлэх ухаанчаар, бодитой үнэлэх, урамшуулах оновчтой тогтолцоо бий болсон байна.

Стратегийн зорилго – 4. Нийгэмд мэдлэгээр манлайлж, нийгмийн тэргүүний үйлчлэгч нь байна.

<p><u>Стратеги зорилт 4.1.</u> Иргэний нийгмийн төлөвшил, бүх нийтийн боловсролд оруулах хувь нэмрийг дээшлүүлнэ.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Төр, бизнесийн байгууллага, иргэдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, олон нийттэй харилцах нэгдсэн сүлжээг бий болгох. • Сургалтын төвүүдийн удирдлага, санхүүжилт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг оновчтой болгох. • Нийгэм, иргэдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн сургалтын чиглэлүүдийг өргөжүүлэх. • Төрийн бус байгууллага, хувийн хэвшлүүд, иргэдтэй тал бүрийн хамтын ажиллагаа өргөжүүлэх.
<p><u>Стратеги зорилт 4.2.</u> Бүс, орон нутгийн эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд сургуулийн</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Бүс, орон нутгийн нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тодорхой

<p>оролцоог нэмэгдүүлнэ.</p>	<p>чиглэлүүдээр судалгааны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.</p> <ul style="list-style-type: none"> • Төгсөгчдийг ажлын байртай болгоход дэмжлэг тусалцаа үзүүлэх, зуучлах үйл ажиллагаа явуулах.
<p><u>Стратеги зорилт 4.3.</u> Сонирхогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, насан туршийн боловсролын харилцааг бий болгоно.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Гадаад орнуудын оюутнуудыг элсүүлэн суралцуулах. • Төгсөгчдийн төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх, зэрэг ахиулах сургалтын төрлүүдийг нэмэгдүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх. • Төгсөгч, дэмжигчдийн холбоодын үйл ажиллагааг тогтмолжуулж, үр дүнг дээшлүүлэх.

Гүйцэтгэлийн шалгуур:

- Мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх болон төгсөлтийн дараах сургалтууд өргөжиж, санхүүгийн орлого нэмэгдсэн байна.
- Багш нар бүс, орон нутгийн эдийн засаг, нийгмийн тодорхой чиглэлүүдээр 5-аас доошгүй судалгааны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.
- Гадаадын 2- оос доошгүй орнуудын оюутнууд элсэн суралцдаг болсон байна.
- Төгсөгч, дэмжигчдийн холбоодын ажил хэрэгч, үр бүтээлтэй байнгын хамтын ажиллагаа тогтож, сургуулийн санхүүжилтэнд тодорхой хувь нэмэр оруулдаг уламжлалтай болсон байна.

Хүрэх үр дүн:

- Сургууль, төр засаг, төрийн бус байгууллагууд, нийгмийн бүлгүүд, иргэдийн хооронд ажил хэрэгч холбоо тогтож, тэдэнд их сургуулийн нийгмийн үйлчилгээний үр шимийг хүртэх нөхцөл бүрдэж, сургуулийн нийгмийн үнэ цэнэ дээшлэнэ.
- Сургуулийн Оюутны холбоо болон Төгсөгч, дэмжигчдийн холбоодын үйл ажиллагаа тогтмолжиж, хамтын ажиллагааны бодит үр дүн сайжирна.
- Сургууль, бизнес, аж ахуйн байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжиж, сургалт, судалгааны санхүүгийн эх үүсвэр нэмэгдэнэ.

Стратегийн зорилго - 5. Байгууллагын бие даасан байдлыг хангаж, менежментийн олон улсын шилдэг арга барилыг нэвтрүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангана.

<p><u>Стратегийн зорилт 5.1.</u> Сургуулийн сургалт, судалгааны орчинг сайжруулна.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Орчин үеийн шаардлага хангасан сургалтын лабораторуудыг нэмэгдүүлэх. • Орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн шинэ номын сан барих. • Оюутны дотуур байрны урд талбайд “Төгсөгчдийн төгөл” байгуулах.
<p><u>Стратегийн зорилт 5.2.</u> Сургуулийн дэргэд туслах аж ахуйг хөгжүүлнэ.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Газар тариалангийн талбайг нэмэгдүүлэх. • Тариалах төмс, хүнсний ногооны нэр төрлийг нэмэгдүүлэх
<p><u>Стратегийн зорилт 5.3.</u> Сургуулийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.</p>	<p><u>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</u></p> <ul style="list-style-type: none"> • Төсвөөс гадуурх санхүүгийн эх үүсвэрүүдийг бий болгох.

Гүйцэтгэлийн шалгуур:

- Орчин үеийн шаардлага хангасан сургалтын лаборатори 2-оос доошгүй тоогоор нэмэгдсэн байна.
- Зарим барилга, байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийгдсэн байна.
- Сургуулийн тариалалтын талбай 20-50 сотоор нэмэгдэж, тариалдаг хүнсний ногооны нэр төрөл 3-аас доошгүй тоогоор нэмэгдсэн байна.
- Төсвөөс гадуурх санхүүгийн эх үүсвэрүүдийг бий болгож, нийт санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлдэг болсон байна.

Хүрэх үр дүн:

- Багш, ажилтан, албан хаагчид, оюутнууд тав тухтай ажиллаж, амьдарч, суралцах, амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай нөхцөл бүрдэнэ.
- Олон эх үүсвэр бүхий санхүүгийн найдвартай тогтолцоо бүрдэнэ.

4.6. Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийн тойм

МУИС-ийн Завхан сургуулийн хөгжлийн ахиц дэвшлийг доорх гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтээр хэмжих бөгөөд өнөөгийн байдал, 2024 оны зорилт болон завсрын зорилтуудыг дараах байдлаар тодорхойлж байна.

Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүд

	Үзүүлэлт /КРІ/	2014/ 2015	2018	2021	2024
1	Тэргүүлэх судлаач эрдэмтдийн нийт багшид эзлэх хувийн жин	-	5%	10%	65%
2	Олон улсын түвшинд хянан магадлалтай импакт фактор бүхий мэргэжлийн сэтгүүлд хэвлэгдсэн бүтээлийн нэг багшид ногдох тоо	-	0.03%	0.06%	0.09%
3	Эрдэм шинжилгээ, судалгаа, гэрээт ажил, технологи дамжуулалт, инновацийн орлогын нийт орлогод эзлэх хувийн жин	-	0.5%	1.0%	1.5%
4	Эрдмийн зэрэг цолтой багшийн нийт багшид эзлэх хувийн жин	7.1%	10%	20%	30%
5	Гадаад багшийн нийт багшид эзлэх хувийн жин	-	5%	8%	10%
6	Гадаад оюутны нийт оюутанд эзлэх хувийн жин	-	1%	6%	6%
7	Ахисан түвшний оюутны нийт оюутанд эзлэх хувийн жин	-	1%	2%	3%
8	Суралцагчдын сэтгэл ханамж	65%	70%	75%	80%
9	Төгсөгчдийн ажил эрхлэлт	61%	65%	70%	75%
10	Олон улсад магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрийн нийт хөтөлбөрт эзлэх хувийн жин	-	10%	20%	30%
11	Оюутан багшийн тооны харьцаа	14:1	18:1	21:1	21:1
12	Олон нийтийн санаа бодлын индекс	-	50	60	80
13	Сургалтын төлбөр болон улсын төсвөөс бусад санхүүжилтийн эх үүсвэрийн нийт орлогод эзлэх хувийн жин	13.2%	14.0%	15.0%	16%
14	Анги танхимын ээлж ашиглалтын коэффициент	1.0%	1.0%	1.0%	1.0%
15	Судалгааны лабораторийн талбайн өөрчлөлтийн коэффициент	1.0%	1.0%	1.0%	1.0%

4.7. Эрсдлийн удирдлага

Стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд тодорхой эрсдэл үүсч болзошгүй бөгөөд тэдгээрийг тооцож, урьдчилан сэргийлэх болон засан залруулах арга хэмжээ авах шаардлага үүснэ.

Стратегийн зорилго – 1. Судалгааны хамрах хүрээ, түвшнийг үндэсний хэмжээний тэргүүлэх жишигт нийцүүлэх.

Томсон-Ройтерсийн индексбүхийолонулсынсэтгүүлдэрдэм шинжилгээ, судалгааны 3-аас доошгүй бүтээлийг хэвлүүлнэ гэсэн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд багшнарнын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дадлага туршлагыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, семинар зохион байгуулан эрдэм шинжилгээний ажлын үр дүнд анхаарч ажиллах ёстой. Үүний үр дүнд дээрх зорилгыг хангахын зэрэгцээ энэ зорилгод тусгагдсан бусад зорилтууд ч биелэх бүрэн боломжтой юм.

Бие даасан эрдэм шинжилгээний сэтгүүлтэй болохын тулд судалгаа шинжилгээг хийж эрэлт хэрэгцээг нь олж харах, сэтгүүлтэй болсноор ямар давуу талтай болох, зардлыг нь хаанаас санхүүжүүлэх, буцаад хаанаас зардлаа нөхөх, сэтгүүлд бүтээлээ нийтлүүлэх эрэлтийг судлаж, бусад их дээд сургууль, судалгаа эрдэм шинжилгээний байгууллагуудтай холбоо тогтоох, сэтгүүлээ сурталчлан таниулах, жилд хэдэн удаа гаргах талаар шийдвэр гаргасны дараагаар сургуулийнхаа жилийн төсөвт суулгаж өгснөөр энэ зорилт биелэх боломжтой юм.

Шинэ гарааны бизнес эхлүүлэхийн тулд маш их судалгаа шинжилгээ хийх хэрэгтэй бөгөөд энэ нь эрсдлийгбагасгана гэж үзэж байна. Шинэ гарааны бизнес эхлүүлэхэд их зардал гарах боловч цаашид үр өгөөжөө өгөх боломж бүрэн бий гэж үзэж байна. Зах зээлийнхээ багтаамж, эрэлт хэрэгцээг харгалзан үзэж орон нутгийн төр, захиргааны байгууллагуудтай нягт уялдаа холбоотой ажиллаж тэдний дэмжлэгийн тусламжтайгаар гарах зардлын тодорхой хэсгийг гаргуулах боломжтой.

Стратегийн зорилго – 2. Сурах ба багшлах үйл явцыг үндэсний хэмжээний тэргүүлэх түвшинд хүргэх.

Багш, оюутнуудад сургалтын SISI программын давуу талын талаар мэдлэг олгох сургалт явуулах, багш нарт сургалтын SISI программ ашиглалтын талаарх дүрэм, журамтай болсноор сургалтын SISI программын ашиглалт 100%-д хүрэх бүрэн боломжтой.

Өөрийн сургуулийн онцлог, ажлын байрны эрэлт хэрэгцээ болон бүс нутгийнхаа зах зээлийг судалснаар Зах зээлийн эрэлтэд нийцсэн бакалаврын 3-аас доошгүй шинэ хөтөлбөрийг нэмж хэрэгжүүлэх боломжтой юм. Энэ тоог явцын дунд төлөвлөгөний хэрэгжилтэнд үнэлгээ хийхэд эргэн харж тооцоолох хэрэгтэй.

Бакалаврын 3-аас доошгүй хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэлд оруулахад тус хөтөлбөр өөрийн зардлаа бүрэн нөхөж байх гэсэн шаардлагыг хангахгүй байх эрсдэл байна гэж үзэж байна. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд хөтөлбөрүүдээр элсэж байгаа элсэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилтыг тавьж ажиллах төлөвлөгөөтэй байна. Энэ тоог явцын дунд төлөвлөгөний хэрэгжилтэнд үнэлгээ хийхэд эргэж харах боломжтой.

Магистрын 5-аас доошгүй хөтөлбөр хэрэгжүүлж, бие даасан “Хамгаалах зөвлөл”-тэй болсон байх гэсэн зорилтын хувьд сургалтын үйл ажиллагаа явуулах эрдмийн зэрэг, цолтой багш нар дутмаг, элсэгчдийн тоо хүрэхгүй байх эрсдэлтэй гэж үзэж байна. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд эрдмийн зэрэг цолтой багшийн хувийн жинг өсгөх бүрэн боломжтой байна гэж үзэж байна. Хөдөлмөрийн зах зээлийн байдлыг харгалзан үзэж, эрдмийн зэрэг цолгүй багш шинээр авахгүй байх, одоогоор ажиллаж буй зэрэггүй багш нарт тавих шаардлагыг өндөржүүлэх зэрэгт анхаарч, багшлах боловсон хүчнийг чанаржуулах бодлого баримтална. Мөн зэх зээлийнхээ эрэлт хэрэгцээг судлан хэрэгцээт 5 магистрын хөтөлбөр хэрэгжүүлснээр элсэгчдийн тоо нэмэгдэнэ гэж үзэж байна.

Орчин үеийн сургалтын технологийг нэвтрүүлж, цахим сургалтыг бүх түвшинд хэрэгжүүлдэг болсон байна гэсэн зорилтын хувьд өндөр зардалтай бөгөөд хөтөлбөрийн энэ зорилтод хүрэхгүй байх эрсдэлтэй гэж үзэж байна. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд МУИС болон АХБ-ны Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд дэмжлэг үзүүлэх бодлого баримталж байгааг судалж, төсөл бичиж зарим хэсгийг шийдвэрлэж болно гэж үзэж байна.

Стратегийн зорилго- 3. Хүний хөгжлийг орчин үеийн шаардлагын түвшинд хүргэх

Нийт багш нарын 20-оос доошгүй хувь нь гадаадын их, дээд сургуульд мэргэжил дээшлүүлж, 10-аас доошгүй хувь нь магистр, докторын зэрэг хамгаалсан байна гэсэн зорилтын хувьд багш нарын эрдмийн ажил хийх чадвар, гадаад хэлний мэдлэгийг нь нэмэгдүүлэх болон эрдмийн зэрэг цолгүй багш шинээр авахгүй байх, одоогоор ажиллаж буй зэрэггүй багш нарт тавих шаардлагыг өндөржүүлж МУИС-ийн журмыг баримтлах,

улмаар багшлах боловсон хүчнийг чанаржуулах бодлого баримталж ажиллавал энэ зорилт бүрэн биелэх боломжтой гэж үзэж байна.

Мөн гадаадын их, дээд сургуульд мэргэжил дээшлүүлсэн багш нар эргээд сургуульдаа ирж ажиллахгүй байх эрсдэл үүсэх магадлалтай учир буцаад сургуульдаа ирж ажиллах таатай нөхцөл боломжоор хангах бодлогын бичиг баримт боловсруулан баримталж ажиллавал энэ зорилт бүрэн биелэх боломжтой гэж үзэж байна. Стратегийн зорилго-3-ийн хувьд ямар нэгэн томоохон эрсдэл үүсэхгүй гэж үзэж байна.

Стратегийн зорилго-4. Нийгэмд мэдлэгээр манлайлж, нийгмийн тэргүүний үйлчлэгч байх.

Гадаад 2-оос доошгүй оюутантай болсон байна гэсэн зорилтын хүрээнд англи хэлний багш хөтөлбөрийг шинээр нээж хэрэгжүүлэх, гадаад багштай болох, оюутан солилцоог өргөжүүлэх, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг системтэй үе шаттайгаар авч хэрэгжүүлбэл энэ зорилго хэрэгжих боломжтой. Энэ тоог явцын дунд төлөвлөгөний хэрэгжилтэнд үнэлгээ хийхэд эргэж харах боломжтой.

Сургууль, төр засаг, төрийн бус байгууллагууд, нийгмийн бүлгүүд, иргэдийн хооронд ажил хэрэгч холбоо тогтоожоож чадвал энэ зорилтын хувьд ямар нэгэн эрсдэл үүсэхгүй гэж үзэж байна.

Сургуулийн Оюутны холбоо болон Төгсөгч, дэмжигчдийн холбоодтой тасралтгүй холбоотой ажиллаж үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллавал энэ зорилт эрсдэлгүй гэж үзэж байна.

Стратегийн зорилго – 5. Байгууллагын бие даасан байдлыг хангаж, менежментийн олон улсын шилдэг арга барилыг нэвтрүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангах.

Орчин үеийн шаардлага хангасан сургалтын лаборатори 2-оос доошгүй тоогоор нэмэгдсэн байна, зарим барилга, байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийгдсэн байна гэсэн зорилтууд нь хэт өндөр зардалтай бөгөөд хөтөлбөрийн энэ зорилтод хүрэхгүй байх эрсдэл байна гэж үзэж байна. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд улсын төсвийн санхүүжилт болон АХБ-ны “Дээд боловсролын шинэчлэл төсөл”-ийн дэмжлэгийг авах боломжтой гэж үзэж байна. Энэ тоог явцын дунд төлөвлөгөний хэрэгжилтэнд үнэлгээ хийхэд эргэж харах боломжтой. Дээрхи санхүүжилтийн эх үүсвэрээс гадна өөрийн санхүүгийн эх үүсвэрүүдийг бий болгож шийдвэрлэж болно.

Нийт санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг сургалтаас бусад орлогоор бүрдүүлдэг болсон байна гэсэн зорилтын хувьд Гарааны бизнесийн үйл ажиллагаа болон “Бизнес-Инноваци” төвийн үйл ажиллагааг тогтворжуулж түүгээр дамжуулан орж ирэх орлогыг нэмэгдүүлснээр энэ зорилт хэрэгжих бүрэн боломжтой юм.

4.8. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, хяналт-үнэлгээ

Сургууль стратеги төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх дунд болон богино хугацааны бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан мөрдөж ажиллана.

Захиргааны зөвлөл стратеги төлөвлөгөөний хүрээнд сургуулийн алба, нэгжүүдийг бодлогын удирдлагаар хангаж, үйл ажиллагааны хэрэгжилтэнд завсрын хяналт, үнэлгээ хийх ажлыг хичээлийн жил тутам зохион байгуулна.

Стратеги төлөвлөгөөний явц, хэрэгжилтийн үр дүн, ахиц дэвшил, тулгамдсан асуудлуудыг хичээлийн жилийн эцэст Захиргааны зөвлөлөөр тусгайлан хэлэлцүүлж, дүгнэлт, шийдвэр гаргуулна.

Сургуулийн Эрдмийн зөвлөл стратеги төлөвлөгөөний биелэлтэнд 3 үе шаттай үнэлгээ, дүгнэлт хийх ба эхний үе шат 2018 он, хоёр дахь үе шат 2020 он, 2024 онд тус тус хэрэгжүүлнэ.

Стратеги төлөвлөгөө боловсруулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Дэмид /Эрдэм шинжилгэ, хамтын ажиллагааны албаны дарга, доктор,дэд проф/

Нарийн бичгийн дарга:

Г.Уранбаяр /Нягтлан бодох бүртгэлийн тэнхмийн багш,магистр/

Гишүүд:

Д.Бямбадорж /Сургалтын албаны дарга, докторант/

Д.Очирпүрэв /Санхүү, хангамж үйлчилгээний албаны дарга/

Ж.Норолхоожав /Бизнес, эдийн засгийн тэнхмийн багш, докторант/

Д.Оюунпүрэв /Санхүү, банкны тэнхмийн багш, докторант/

Б.Болорчимэг /Нягтлан бодох бүртгэлийн тэнхмийн багш, магистр/

Г.Жундаамаа /Мэдээллийн технологийн тэнхмийн багш, магистр/

Б. Дэлгэр /Мэдээллийн технологийн тэнхмийн багш/